



ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2023 оны 06 сарын 02 өдөр

Дугаар А/62

Улаанбаатар хот

Ажлын байрны тодорхойлолт батлах тухай

Хөдөлмөрийн тухай хуулийн 103 дугаар зүйлийн 103.3.2, Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, Компанийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.5.5, Хөдөлмөрийн дотоод журмын 4.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Компанийн ажлын байрны тодорхойлолтыг хавсралт ёсоор баталсугай.
2. Батлагдсан ажлын байрны тодорхойлолтыг нийт ажилтнууд болон шинээр томилогдох ажилтантай хөдөлмөрийн гэрээ байгуулахад танилцуулах, хувийн хэрэгт хавсаргах ажлыг зохион байгуулж ажиллахыг Захиргаа удирдлагын газар (М.Гансэлэм)-т даалгасугай.
3. Ажлын байрны тодорхойлолтод заасан тавигдах шаардлага, чиг үүргийг мөрдлөг болгон ажиллахад хяналт тавьж удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг нийт газар, нэгжийн дарга нарт үүрэг болгосугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засгийн газрын онцгой бүрэн эрхт төлөөлөгчийн Ажлын алба (Д.Сэрээдорж)-нд даалгасугай.

ЗАСГИЙН ГАЗРЫН ОНЦГОЙ
БҮРЭН ЭРХТ ТӨЛӨӨЛӨГЧ



Н.МЯГМАР

1423001230798